

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

### МОНГОЛ ДАХЬ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ, ТҮҮНИЙ ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

Т.Баасансүрэн\*

\* “Улаанбаатар Эрдэм” их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), профессор

**Түлхүүр үг:** чөлөөт хэвлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрөл, медиа групп, сэтгүүлчдийн бичлэгийн арга барил, уран чадвар, мэдээллийн эх сурвалж

Өнөөдөр Монголд 111 сонин гарч байгаагаас 11 нь өдөр тутмынх. Мөн долоо, арав хоног, сар, улирал тутмын 90 сэтгүүл хэвлэгдэж буй. 72 радио байгаагаас ихэнх нь FM-үүд бөгөөд 104 телевиз үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрээс 16 телевиз улс орон даяар нэвтрүүлгээ цацаж байгаа. 200 орчим сайт ажиллаж байгаа гэсэн статистик бий<sup>1</sup>.

Энэ бол гуравхан сая хүн амтай Монгол Улсын хувьд том тоо. Сонин, сэтгүүлүүдийн тоо хэмжээ өнөөгийн хөөсөө нэг их нэмэгдэхгүй байх магадлалтай. Харин FM-үүд, теле суваг, сайтууд зах зээлийн хуулийн жам ёсоор хөгжиж шалгарлын явцад тооноос чанарт шилжих нь гарцаагүй. Өнөөдөр ч эл үйл явц ажиглагдаж байгаа бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрөл Монголд буй болж байна гэж хэлж болно. Өөртөө арваад хэвлэл мэдээллийн хэрэгслийг нэгтгэсэн Медиа группүүд гэхэд Монголд “Монгол ньюс”, “Монгол макс

медиа”, “Масс медиа”, “Медиа групп”, “Женко”, “Гэрэл палас” байж байх жишээтэй. Хэвлэл, мэдээллийн ийм хүчирхэг төвлөрөл буй болж байгаа нь нэг талаас боловсон хүчин, техник хэрэгсэл, нийтлэл нэвтрүүлгийн цэгцтэй бодлогыг төлөвлөж хэрэгжүүлэх зэрэг эерэг сайн талтай ч, нөгөө талаас мэдээллийг монопольчлох, нийгмийн сэтгэл зүйг хүссэнээрээ залж чиглүүлэх боломжийг цөөхөн бизнесчид, улстөрчдийн гарт олгож буйгаараа хортой.

Монголын хэвлэл, мэдээллийн салбарт өнөөдөр 4.5 мянган хүн ажиллаж, тэдний залгамж халааг 18 их, дээд сургуулийн сэтгүүл зүйн сургалтаар бэлтгэн гаргаж байна. МҮОНРТ, МОНЦАМЭ агентлагийг эс тооцвол цөөнгүй нь, гэхдээ илүү авьяаслаг, бүтээлч хэсэг нь дээрх медиа группүүдэд ажиллаж байгаа нь нууц биш.

Монгол дахь олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийн систем үүсч, хөгжиж, төлөвшиж бүрэлдэх үйл явц 104 жилийн түүхийг ардаа орхижээ. Эхлэл нь 1913 оны 3 дугаар сарын 6-нд анхны дугаараа гаргасан “Шинэ толь хэмээх бичиг” сонин юм. 1921-1991 он хүртэлх далан жилд манай хэвлэл мэдээлэл ангич, намч,

ардач хэвлэлийн түүхэн замналыг туулжээ. 1991 оны ардчилсан хувьсгалын үр дүнд Монголд чөлөөт хэвлэл мэдээлэл жинхэнэ утгаараа хөгжих бодит боломж бүрдсэн. Гэхдээ энэ нь чөлөөт хэвлэлийн уламжлал Монголд урьд нь огт байгаагүй гэсэн үг хараахан биш. Ямар сонин, сэтгүүл, радио, телевиз, цахим мэдээллийн хэрэгслийг чөлөөт хэвлэл гэх вэ гэдгийг шалгаж тодорхойлдог үндсэн есөн шалгуурыг сэтгүүл зүйн эрдэмтэн мэргэд нэгэнт боловсруулж буй болгож чадсан бөгөөд түүнийг нь олон улсын сэтгүүл зүйн практикт түгээмэл хэрэглэж байна. Эдгээр шалгуураар хэмжиж шалгаж үзэхэд 1913-1914 онд 20 дугаар гаргасан “Шинэ толь хэмээх бичиг” сонин, 1915-1920 онд 103 дугаар гаргасан “Нийслэл хүрээний сонин бичиг” сонин тэрхүү есөн шалгуурын наймыг нь ягштал хангаж чадаж байсныг би урьд нь “Монголд Чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь”<sup>2</sup> цуврал 6 ботийнхоо тэргүүн дэвтэрт ихэд дэлгэрэнгүйгээр нотолж бичсэн учир тэр тухайг ахин нуршилгүй орхиё. Энэ бол их соён гэгээрүүлэгч, нэрт эрдэмтэн Жамсраны Цэвээн хийгээд түүний хамтран зүтгэгч Д.Бодоо, хошой гүн Бадрахбаатар, Бунибазарын Дорж зэрэг манай салбарыг үүсгэн байгуулсан үеийн сэтгүүлчид, ахмад үеийнхний маань гайхамшигт гавьяа билээ.

**Т**ийм учраас Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил төлөвшил, өнөөгийн байдал, цаашдын төлвийн талаар ярилцахдаа та бид түүнийг уламжлал ба шинэчлэлийн уялдаа холбоон дунд нь авч үзэж, холбогдох гаргалгааг хийж байх нь илүү шинжлэх ухаанч, илүү итгэл үнэмшилтэй байх болно. Жишээ нь, 1921-1991 оны хоорондох Монголын

далан жилийн хэвлэлийн түүхийг дан хараар будаж ангич, намч, ардач хэвлэл, ямар ч эрх чөлөө байгаагүй хэмээн хэрэгсэхгүй орхиж бас болохгүй. Учир нь сэтгүүл зүй бол өөрийн өвөрмөц онцлог, хөгжлийн зүй тогтлыг шаарддаг сонирхолтой шинжлэх ухаан юм. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, тэнд ажиллаж байгаа мэргэжлийн сэтгүүлчдийн бусдаас онцгойрон ялгарах нэг түгээмэл шинж төрх бол байнгын хөгжил хөдөлгөөн, хувьсал өөрчлөлтөд оршдог явдал. Өөрөөр хэлбэл шинийг эрж хайх, ирээдүй өөд тэмүүлэх, аливаа асуудлыг нэг өнцгөөс биш олон талаас нь олж харахыг эрмэлзэх, юмыг хүний бодоогүй өөр өнцгөөс өөлж баалж шүүмжлэлтэйгээр хандах зэрэг нь сэтгүүлчийн мэргэжлийг эзэмшигчдийн хувьд төрөлх, заяамал чанар нь юм. Энэ нь аль ч цаг үед сэтгүүлчдийн бичлэгийн арга барил, уран чадварын өөрчлөлт шинэчлэлээр илрэн гарч байдаг. Өөрийгөө эвдэх гэж, бичлэгийн арга барилаа өөрчилж шинэчлэх гэж тэд байнга тэмүүлцгээнэ. Өрсөлдөнө, уралдана. Үүнд нь хүчтэй түлхэц үзүүлдэг, хөшүүрэг болж өгдөг нэг гол хүчин зүйл нь сэтгэлгээний эрх чөлөө. Сэтгэн бодох эрх чөлөө нь хэзээ ямагт чөлөөт хэвлэлийг, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг шаардаж байдаг.

Энэ үүднээс авч үзэх юм бол социализмын гэгдэх он жилүүдийн хэдэн үеийн сэтгүүлчдийн бичлэгийн ур чадвар, арга барилд тунгаамал шижир алтан сондор зөндөө. Бямбын Ринченгийн “Их говийн зоригтон хүмүүс”, Мөнгөний Бизъяагийн “Өвлийн нүүдэл” найруулал үүний тод жишээ. Тэд бараг бүгдээрээ яг л өнөөдрийн бидний нэгэн адил сэтгэлгээний эрх чөлөөг эрхэмлэж, өөрсдийгөө эвдэж шинэчлэхийн

төлөө тэмүүлцгээж, уран чадвараараа уралдаж өрсөлдөж байсан байдаг.

Сэтгүүл зүйн салбарын амьдрал, үйл ажиллагаа, уран бүтээлчдийн арга ажиллагаа, өөрчлөлт шинэчлэл хэзээ ч тогтонги хөдөлгөөнгүй байдлыг зөвшөөрдөггүй бөгөөд байнгын өсөлт хөгжилтийг шаардаж буцалж бургилж байдагт хамаг учир оршино. Шинжлэх ухаан, техникийн ололт амжилт хамгаас түрүүлж мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд тусгалаа олдог, бүх төрлийн шинжлэх ухааны шинэ дэвшилт ололт, өөрчлөлт шинэчлэл хүний нийгэмд мэдээллийн хэрэгслээр, сэтгүүлчдээр дамжиж нийтийн хүртээл болж түгэж дэлгэрдэгтэй энэ нь шууд холбоотой юм. Өөрөөр хэлбэл өөр ямар ч мэргэжилд байдаггүй өвөрмөц онцлог буюу байнгын шинэчлэл өөрчлөлт дотор сэтгүүлчид байж, хүн төрөлхтний хамгийн дэвшилт үзэгдэл, шинжлэх ухаан, техникийн сүүлийн үеийн ололт амжилтыг бусдаас түрүүлж мэдэж мэдэрч, түгээж дэлгэрүүлж байдаг нь тэдэнд илүүтэйгээр дэвшиж хөгжих, шинийг мэдэж мэдрэх боломжийг олгодог байна. Тэр хэмжээгээрээ тэд нийгэмдээ хошуучлагч, манлайлагч үүрэг гүйцэтгэх бөгөөд нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэхэд үг, үйлдлээрээ шууд оролцож байдаг. Орчин үеийн телевизийн хүчирхэг сувгууд, мэдээллийн агентлагууд, манай сэтгүүл зүйн маргаашийн ирээдүйг тодорхойлогч цахим мэдээллийн хэрэгслүүд нь хүн төрөлхтний сод ухаантнуудын ер бусын санаа бодлыг хамгаас түрүүлж өөртөө бүтээлчээр авч ашиглагчид байдаг нь тэнд ажиллаж байгаа уран бүтээлчдэд мэдээж эерэгээр нөлөөлдгийг бас нэмж тэмдэглэх учиртай. Энэ мэт үйл ажиллагааны өвөрмөц нөхцөл байдал, өвөрмөц орчин, өвөрмөц

сэтгэлгээ, зогсолтгүй үргэлжлэх эрэл хайгуул, урлан бүтээхийн төлөөх уралдаан өрсөлдөөн зэрэг нь эрх чөлөөг хэзээ ямагт дээд зэргээр нэхэн шаардаж байдаг байна. Үүгээр онгодтой сэтгүүлчдийн чөлөөт хэвлэлийн төлөөх тууштай тэмцлийн нэг учир шалтгааныг тайлж тайлбарлаж болно.

**Е**рээд онд Монголд ардчилсан хувьсгал ялснаар чөлөөт хэвлэл жам ёсныхоо дагуу жинхэнэ утгаараа хөгжиж цэцэглэх нийгмийн бодит суурь дэвсгэр бий болжээ. Ардчилсан хувьсгалын анхдагчид хэвлэлийн эрх чөлөөг нэхэн гарч ирсэн нь санамсаргүй явдал байгаагүй. Хүссэн хүн бүр хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг эрхлэх боломжтой болсон. Сонин хэвлэл борооны дараах мөөг шиг олширсон. Шар хэвлэл Монголд цэцэглэсэн. Энэ бүхний үндэс суурь нь 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хууль байлаа. Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөгөөр иргэд бүрэн хангагджээ.

Олон намын системд шилжсэн Монгол Улсын парламент 1998 онд Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөний тухай хуулийг батлан гаргав. Нийтлэл, нэвтрүүлгийн утга агуулгад цензур тавихгүй, тийм байгууллагыг санхүүжүүлэхгүй гэж Монгол Улс нэр төртэй тунхаглав. Төр засаг, түүний харьяаны яам газрууд, аймаг, хотын захиргаа ямарваа төрлийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийг эрхлэн гаргах эрхээсээ татгалзсан билээ. Засгийн газрын тохируулагч агентлаг-Радио телевизийн Хэрэг эрхлэх газар, МОНЦАМЭ агентлагийг татан буулгасан юм. Тусгай хууль гаргах замаар тэдгээр байгууллагыг олон нийтийн статустай болгож хувиргахаар УИХ-ын 103 дугаар тогтоолоор заасан.

Улсын Их Хурал 2003 онд Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг баталж олон улсын өмнө, НҮБ-ын Хүний эрхийн хорооны өмнө Монгол Улсын төр засаг хэвлэл мэдээллийн ямар нэгэн хэрэгслийг эрхшээлдээ байлгахгүй гэж амлалт авав. Амлалтаа хэрэгжүүлж чөлөөт хэвлэлийн эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чухал хөшүүрэг болсон МҮОНРТ-ийн тухай хуулийг 2005 онд батлан гаргав. Монголын түүхэнд анх удаа радио, телевизийн хүчирхэг хэрэгсэл олон нийтийн мэдэлд шилжив.

“Фридом хаус”, “Хил хязгааргүй сэтгүүлчид” зэрэг олон улсын нэр хүндтэй байгууллагууд ардчиллыг бэхжүүлж, чөлөөт хэвлэлийг хөгжүүлэх чиглэлээр хийж буй

эдгээр алхмыг нь үнэлж Монгол Улсыг хэвлэлийн харьцангуй эрх чөлөөтэй улс орнуудын тоонд багтаав. Энэ бол бахархам сайхан үйл явдал байлаа. Монголын сэтгүүлчид эл алдар нэрийг тэмцэж байж олж авсан билээ. 2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчөөр анх удаа сэтгүүлчийн мэргэжилтэй Цахиагийн Элбэгдорж сонгогдов. Тэрбээр хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай 1998 оны хуулийг улам боловсронгуй болгон сайжруулж шинэчлэн найруулна гэж амлав. Сэтгүүлчид, сэтгүүл зүйн эрдэмтэд, улстөрчдийн төлөөлөгчид дээрх хуулийн шинэчилсэн найруулга дээр бүтэн хоёр жил ажиллаж хэдэн зуун үнэт санал санаачлага гаргав. Хэвлэл

мэдээллийн хэрэгслийг эзэмшигч эздийг ил тод зарлах, сэтгүүлчид олж авсан мэдээллийнхээ эх сурвалжийг нууцлах эрхээр хангагдах (шүүх шаардахаас бусад тохиолдолд), УИХ-ын 103 дугаар тогтоолын заалтыг хэрэгжүүлж МОНЦАМЭ агентлагийг олон нийтийн статустай болгох, зарим аймгийн иргэдийн хурал өөрийн удирдлагын системээр гул барьж

сонин, сэтгүүл сэм гаргаж, Засаг даргын Тамгын газар өөрсдийн дуулгавартай “зарц” нарын нэр дээр радио, телевизийг нэр заан хувьчлаад нидэр дээрээ өөрсдийн улстөрийн зорилгод ашиглаж байгааг газар авахуулахгүй зогсоох зэрэг олон чухал, үнэ цэнэтэй саналууд хуримтлагдсан билээ.

«

***МҮОНРТ хуулиар олон нийтийн статустай болсон мэт харагдаж байгаа ч үнэн хэрэгтээ Монголын төр засагт үйлчилсэн хэвээр байгаа юм. Учир нь Удирдах зөвлөлийн гишүүдийг олон нийтийн болоод төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийнхэн шууд өөрсдөө мэдэж Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд нь оруулж чаддаггүйд буй юм***

»

МҮОНРТ-ийн Удирдах зөвлөлийн 15 хүнийг төр засгийн өндөрлөгийн гурван субъектээс (Монгол Улсын Ерөнхийлөгч 4 хүн, Монгол Улсын Их Хурал 7 хүн, Монгол Улсын Засгийн газар 4 хүнийг тус тус санал болгодог) санал оруулж УИХ-аар батлуулдаг. Батлагдсан тэдгээр хүмүүс нь эргээд эзэддээ үйлчилдэг нь өнгөрсөн жилүүдийн практикаар их тод харагдсан. МҮОНРТ хуулиар олон нийтийн статустай болсон мэт харагдаж байгаа ч үнэн хэрэгтээ Монголын төр засагт үйлчилсэн хэвээр байгаа юм. Учир нь Удирдах зөвлөлийн гишүүдийг олон нийтийн болоод төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийнхэн шууд өөрсдөө мэдэж Удирдах зөвлөлийн бүрэл-

дэхүүнд нь оруулж чаддаггүйд буй юм. Энэ мэт багагүй дутагдал МҮОНРТ-ийн тухай хуульд бий. Жишээ нь, Удирдах зөвлөл нь Хяналтын зөвлөл, Өргөдлийг шалгах хороог өөрсдөө байгуулдаг, тэдгээр нь эргээд Удирдах зөвлөлдөө захирагдаж, түүнд үйлчилдэг. МҮОНРТ-ийн тухай хуулиар тус байгууллагад ажилладаг сэтгүүлчид мэдээллийн эх сурвалжийнхаа нууцыг хадгалах эрхээр хангагдсан байхад Монголын бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажилладаг сэтгүүлчдэд тийм эрхгүй, ялгаварлан гадуурхсан байх жишээтэй.

Энэ бүгдийг нэг мөр болгож хэвлэлийн эрх чөлөөг улам баталгаажуулахад 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулж боловсронгуй болгон сайжруулж гаргах нь үнэхээр чухал ач холбогдолтой байсан билээ. Гэвч Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-д өргөн барьсан дээрх хуулийн төслөө Монголын үндэсний сэтгүүл зүйн 100 жилийн ойн өмнөхөн гэв гэнэтхэн эргүүлэн татаж авсан. Биднийгээ хошгируулчихсан.

**А**ль ч улс орон ардчилсан нийгмийн үнэт зүйлсээ хамгаалж баталгаажуулъя гэвэл нийгэмд “дөрөв дэх засаглал”-ын үүрэг гүйцэтгэгч хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн үйл ажиллагааг янз бүрээр дэмжиж байдаг. Учир нь тэд ард түмнийхээ үнэнийг мэдэх эрхэд үйлчилдэг юм. Ил тодын индэр болж байдаг. Дэлхийн олон арван улс орны өнгөрсөн түүхээс харахад улс төрийн аль ч нам ялгаагүй засгийн эрхэнд удаж олон жилээр суувал ялзарч өмхийрээд ард түмнээсээ муу муухайгаа, далд, хууль бус, бохир үйл ажиллагаагаа нууж хааж эхэлдэг байна. Үүнийг нь олон нийтийн хэвлэл

мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчид илчилдэг. Ил тодын индэр болж, эрх баригчдын үйл ажиллагааг ард түмэнд өдөр тутам мэдээлж, ардчиллын үнэт зүйлсийг хамгаалж байдаг. Энэ утгаар нь чөлөөт хэвлэл, чөлөөт сэтгүүлчдийг ардчилсан нийгмийн “хоточ нохой” хэмээн нэрлэдэг билээ. Үүнээс айж болгоомжилсон эрх баригчид хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг хааж боох, хумих ажилд хүссэн ч, хүсээгүй ч ордог аж. Монгол Улс ардчиллын замд шилжсэн сүүлийн 27 жилийн түүхийг анхааралтайгаар ажиглан харах юм бол энэ үйл явц манайд яг давтагдаж байна гэж хэлж болно. 2011 онд Монгол Улсын Их Хурал ил тод байдал, иргэдийн мэдээлэл авах эрхийн тухай хуулийг батлан гаргаснаар чөлөөт хэвлэлийн төлөө санаа тавих ажилдаа цэг тавьсан юм. Ц.Элбэгдорж өөрийн санаачилсан хуулийг эргүүлэн татсан нь энэ бүхний эхлэл байлаа. 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, уг хуулийг хэрэгжүүлэхээр УИХ-аас гаргасан 103 дугаар тогтоолынхоо заалтыг ч гүйцэд хэрэгжүүлэлгүй орхижээ. Үүний тодорхой баримт нь үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлаг Засгийн газрын мэдэлд байсан хэвээр байгаагаар батлагдана. Олигархиуд, оффшорчид Засгийн эрхийг барьж байгаа цагт чөлөөт хэвлэлийг хөгжүүлэх чиглэлээр Монголын төр ахиад нэг ч зоримог алхмыг хийхгүй. Чөлөөт хэвлэл бол тэдний хувьд тэсрэх бөмбөг, исгэрэх сум юм. Өөрсдийгөө сайн дураараа “алж устгах”-ыг хэзээ ч хүсэмжлэхгүй нь туйлын ойлгомжтой.

Энэ бүхний үр дагавар нь Монгол Улс хэвлэл мэдээллийн харьцангуй эрх чөлөөтэй улс орны тооноос хасагдаж, урагшлах биш ухарсан явдал.

Хэвлэлийн хагас эрх чөлөөтэй улс орнуудын эгнээнд жагсах болжээ. Өнгөрсөн жил манайх 60 дугаар байрт бичигдэж байсан бол 2017 онд 69 дүгээрт орж даруй 9 байраар ухарчээ. Баясах зүйл биш ээ. Монголын сэтгүүл зүй асуудлаар дүүрэн байгаа гэсэн үг. Шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал тун олон байна. Ганц нэгээс нь тухайлбал:

**Нэгдүгээрт,** чөлөөт хэвлэл мэдээллийг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчинг гүйцэд бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай. Монголын төр энэ чиглэлээр урагшаа нэг алхаад хоёр дахь алхмаа хийж чадалгүй гацаад зогсчихсон. “Нэг алхам урагшаа, хоёр алхам хойшоо” ухарчихгүйн тулд юуны түрүүнд хэвлэл, мэдээллийн үйл ажиллагааны ерөнхий хуулиа боловсруулж гаргах нь зүйтэй. Нэг бол цоо шинээр хийнэ, эсвэл 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд шинэчилсэн найруулга оруулж баяжуулах замаар шийдвэрлэнэ.

Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн тухай хуулийг Монголын төр гаргах үүрэгтэй. Энэ нь зөвхөн УИХ-ын 103 дугаар тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлэх төдийгүй олон улсын өмнө, НҮБ-ын Хүний эрхийн хорооны өмнө Монгол Улс “Хүний эрхийн үндэсний хөтөлбөр”-өөр хүлээсэн үүргээ биелүүлэх алхам болох юм.

МҮОНРТ-ийн тухай хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. Энэ хууль хэрэгжээд 12 жилийг ардаа орхих хугацаанд цөөнгүй заалт нь амьдрал, практикт нийцэхгүй байгаа нь ажиглагдаж мэдрэгдсэн. Хамгийн наад зах нь л гэхэд МҮОНРТ-ийн Удирдах зөвлөлийн 15 гишүүнийг төр, засгаас томилдгийг болиулах хэрэгтэй юм. Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, МҮЭ-ийн холбоо зэрэг олон

нийтийн болоод төрийн бус байгууллагууд өөрсдийн төлөөллөө өөрсдөө шууд мэдэж томилон суулга-даг байх нь илүү зохимжтой, илүү үр нөлөөтэй. Тэгж чадаагүй цагт МҮОНРТ хэзээ ямагт төр засгийн дуулгавартай хэрэгсэл байсаар байх болно.

**Ч**өлөөт хэвлэлийн талаарх нийгмийн харилцааны зохицуулалтыг нэг биш, нэг хэсэг өөрөөр хэлбэл багц хуулиар шийдвэрлэнэ. Өөр гарц харагдахгүй байна. Энэ завшааныг ашиглаж зориуд хэлэх нэг зүйл буй. Өнөөдөр Монголд Үндсэн хуулийг шинэчилж өөрчлөх тухай ид ярьцгааж байна. Ардчилал хөгжиж өндөр түвшинд хүрсэн АНУ, Их Британи, Энэтхэг зэрэг улс орны туршлагаас харахад Хүний үндсэн эрхийг, түүний дотор хэвлэлийн эрх чөлөөг хангасан Үндсэн хуулийн заалтад огт гар хүрдэггүй аж. Хасдаггүй. Харин нэмж баяжуулдаг байна. Үүнийг манайхан анхаарахад илүүдэхгүй бөгөөд ХБНГУ зэрэг орны туршлагаар чөлөөт хэвлэлийн эрх чөлөөг улам баталгаажуулаад зогсохгүй сандал ширээтэйгээ зууралдан салж өгөхгүй атлаа ард түмнийхээ төлөө ажиллаж чадахгүй байгаа эрх баригчид, олигархиуд, оффшорчдыг ард түмэн халж өөрчлөх эрхтэй гэсэн заалтыг ч нэмж суулгаж өгөхөд илүүдэхгүй санагдана.

**Хоёрдугаарт,** мэдээллийн аюулгүй байдлын асуудал манайд сэтгэл түгшээх хэмжээнд хүрчээ. Хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээс нийгэмд үзүүлэх нөлөөллөөрөө телевизийн сувгууд онцгой. Тэгвэл өнөөдөр Монголын бүх телевизээр гадаадын, түүний дотор Хятад, Солонгос зэрэг орны олон ангит кино өдөр бүр тасралтгүй гарч байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Үндэсний түүх, хэл, соёл,

өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн”<sup>3</sup> гэсэн тодорхойлолт бий. Монгол Улсын аюулгүй байдал нь оршин тогтнохуйн аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлын цогцоос бүрдэнэ. Аль нэг нь алдагдахад Монгол Улсын тусгаар тогтнолд нөхөж баршгүй аюул, хор уршиг учрах болно. Тэгвэл өнөөдөр Монгол Улсын эдийн засаг гэхэд өмнөд хөршөөсөө 86 хувийн хамааралтай болсон гэсэн статистик байна. Монгол Улсын гадаад худалдааны 70 хувь ганц БНХАУ-д оногддог болжээ. Энэ тоо хэмжээ 40 хувиас хэтэрсэн тохиолдолд нэг улсын хамааралд орно гэж олон улсад үздэг аж.

**М**онгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан эдийн засгийн ухааны доктор Д.Бямбасүрэн гуай “Зууны мэдээ” сонинд өгсөн ярилцлагадаа “Монгол Улс эдийн засгийн тусгаар тогтнолоо бүрэн алдлаа... Энэ нь улс төрийн тусгаар тогтнолд нөлөөлж байна... Энэ бол монголчуудын үеийн үед, хэдэн зууныг дамжиж тэмцэж олсон ололтыг бид эргээд алдаж байна гэсэн үг”<sup>4</sup> гэж ихэд харамсаж өгүүлжээ.

Эдийн засгийн энэхүү хараат байдал мэдээллийн аюулгүй байдалд шууд нөлөө үзүүлж маш хортой үр дагаварт хүргээд байна. Монголын бараг бүх сонин хэвлэл, радио телевиз, мэдээллийн сайтууд хамтран ажиллах гэрээ, хамтарсан төсөл хэрэгжүүлэх нэрээр Хятадын аль нэг хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй “гүзээнд наалдсан дэлүү” шиг ойртон дотносож мөнгө саадаг болжээ. Түүнийхээ хариуг маш өндөр үнээр төлөх өдөр ирж л таарна. Монголын Үндэсний аюулгүй

байдлын тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн маш тодорхой 30 заалт бий. Тэдгээр заалт амьдралд хэрэгжихгүй байна. Зарим эрх б-аригчид түүнийг хэрэгжүүлэхийг “хүсэхгүй” байна.

**Гуравдугаарт**, сүүлийн хорь гаруй жилд Монголын сэтгүүл зүйд чанарын шинжтэй гэж хэлж болохуйц олон өөрчлөлт шинэчлэл гарч байна. Уул уурхайн үйлдвэрлэл, олборлолт түргэн хурдацтай хөгжиж хүрээлэн буй байгаль орчинд нөхөж баршгүй хор хохирол учруулах болсноор экологийн чиглэлийн сэтгүүл зүй хүчтэй хөгжих хандлага илэрхий ажиглагдаж байна. “Өнөөдөр” сонины Хөвсгөл нуурын талаарх цуврал нийтлэл, “Өдрийн сонин” дахь байгаль хамгааллын сэдвүүд, TV-9 телевизийн “Эзэнгүй төрийн эмгэнэл” цуврал нэвтрүүлэг, сэтгүүлч Д.Ганбаяр, М.Буянбадрах нарын “Хүрээлэн” цуврал үүний нотолгоо.

Ерээд оноос цахим сэтгүүл зүй эрчимтэй хөгжиж эхэлснээр нийгэмд болж буй тулгамдсан асуудлаар иргэд санал сэтгэгдлээ илэрхийлэх нь ердийн үзэгдэл болж хувирав. Уг салбарт ажиллагсдын дотор мэргэжлийн сэтгүүлчид харьцангуй цөөн байдгийн улмаас агуулгын доголдол гарч, гоо зүйн учир холбогдол багагүй дагалдаж өгүүлэл шүүмжлэлд өртөх нь элбэг байгаа ч энэ бол Монголд иргэний сэтгүүл зүй хөгжихөд хүчтэй түлхэц үзүүлж байгааг хүлээн зөвшөөрч, зориуд тэмдэглэн хэлэх учиртай.

TV-9 телевизийн “Монгол коммент” өдөр тутмын шууд нэвтрүүлэг жилийн турш буюу 265 хоног (зуны 7, 8 дугаар сард завсарладаг) мянга мянган үзэгчдийг цэнхэр дэлгэцийн өмнө

найдвартай барьж чадаж байгаа нь үүний нэг тод илрэл юм.

Олигархиуд, оффшорчдын үйл ажиллагаа Монголд улам идэвхжиж, ажилгүйдэл, ядуурал нэмэгдэн нийгэмд шударга ёс алдагдаж, авилга, хээл хахууль газар авснаас улбаалж мөшгих сэтгүүл зүй хөгжих үндэс суурь тавигдаж байна. Өөрөөр хэлбэл, эрэн сурвалжлах сэтгүүл зүй нийгмийн захиалга, нэхэл шаардлага болон хувирч байна гэсэн үг юм.

Чөлөөт хэвлэл, мэдээллийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон дээрх чиглэлүүдийг, түүний дотор эрэн сурвалжлах сэтгүүл зүйг дэмжих явдал манай сэтгүүл зүйн амин чухал тулгамдсан асуудал болно. Энэ бол эр зоригийн сэтгүүл зүй юм. Эрүүл саруул, хариуцлагатай, ёс зүйтэй чөлөөт хэвлэлийн тод илрэл юм. Ажил албад халтай, амь насанд аюултай үйл ажиллагаа. Ганц нэг хүн барахгүй. Хамтын зүтгэл, хамтын хүчин чармайлт, харилцан уялдаатай үйл ажиллагааг шаардана. Ихээхэн хүч хөдөлмөр, цаг хугацаа, хүн чанарыг, шударга ёсыг зайлшгүй шаардана.

**Дөрөвдүгээрт**, эдгээр нь эргээд сэтгүүл зүйн шүүмж судлалын хөгжлийг нэхдэг. Энэ бол манай салбарын хамгийн эмзэг асуудлын нэг юм. Монголд сэтгүүл зүйн шүүмж судлал өнгөрсөн зууны хориод оны сүүлчээс эхэлсэн боловч ээдрээ түвэгтэй хүнд бэрх замыг туулж өнөөдрийг хүргэсэн билээ. Сэтгүүл зүйн онол, практикийн тулгамдсан асуудлаар докторын зэрэг хамгаалсан дөч гаруй эрдэмтэн манайд бий. Магистрын судалгаа хийж хамгаалсан нь хоёр зуу хол гарна.

Сэтгүүл зүй буюу “дөрөв дэх засаглал” нь нийгмийг удирдан залж чиглүүлэх хүчирхэг зэвсэг болж байдаг. Өөрөөр хэлбэл нийгмийн сэтгэл зүйг

төлөвшүүлэхэд юугаар ч орлуулшгүй чухал үүрэг гүйцэтгэдэг гэсэн үг юм.

**Э**нэ утгаар нь авч үзэх юм бол сэтгүүл зүйн шүүмж судлал нь хэдхэн хүний хувийн ажил биш. Түүний төлөвшил, хөгжилд нийгэм анхаарал халамж тавьж байх ёстой гэсэн үг юм. Төр засгийн сонирхол байх ёстой гэсэн санааг би онцлон хэлэх гээд байна. Яагаад гэвэл нийгмийг удирдан жолоодоход, нийгмийн сэтгэл зүйг зөв гольдролоор зөв залж чиглүүлэхэд нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчид шиг хэрэгтэй зэвсэг байхгүй. Тэрхүү чухал зэвсгийн алдаа оноог сэтгүүл зүйн шүүмж судлал хэлж өгч байдаг. Мэргэжлийн үүднээс.

Харамсалтай нь манай төр засаг үүнийг огтхон ч ойлгохгүй байгаа юм. Сүүлийн хорь гаруй жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулж сэтгүүл зүйн онол, практикийн тулгамдсан асуудлаар цөөнгүй эрдэмтэнг хамгаалуулж бэлтгэн гаргасан МУИС-ийн Сэтгүүл зүйн эрдмийн зөвлөлийг БСШУЯ нийгмийн ухаан, социологи, хэл бичиг, Монголын утга зохиол зэрэг бусад мэргэжлийн зөвлөлтэй хольж хутган нэгтгэж нийлүүлээд бүрэлдэхүүнд нь сэтгүүл зүйн шинжлэх ухааны эрдэмтдээс ганцхан хүнийг төлөөлөл болгож оруулсны улмаас 2012-2017 оны хооронд гэхэд нэг ч хүн эрдмийн зэрэг хамгаалсангүй.

Сэтгүүл зүйн түүх судлал, онол практикийн тулгамдсан асуудлаар судалгаа шинжилгээ хийж байгаа залуус цөөнгүй байгаа ч шүүмж шүүмжлэлийг барьж авахаасаа тэд дөлж зугтдаг. Учир нь өөрсдөд нь ямар ч ашиггүйгээс тэр. Гавьяа байгуулахгүй, гай авчирч үнэнийг хэлснийхээ төлөө бусдын хараал сонсч, хавчлагад өртөнө. Уран бүтээлийнх нь алдаа



дутагдлыг ил тод хэлж өгөхөд баярлаж талархах хүн тун цөөхөн. Бүгдээрээ л магтуулах дуртай. Гунигтай нь магтуулах хэмжээнд туурвигдсан бүтээлүүд даанч цөөхөн. Ийм байхад сэтгүүл зүйн мэргэжлийн шүүмж шүүмжлэл хөгжих боломж тун хомсхон юм. Энэ бол сэтгүүл зүйн шүүмж судлалыг хөгжүүлэхэд чиглэсэн төрийн бодлого байхгүй, эдийн засгийн хөшүүрэг үгүйлэгдэж буйн баримт.

**Тавдугаарт**, их, дээд сургуулиудаар мэргэжлийн сэтгүүлч боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах асуудалд анхаарал тавих цаг болоод байна. Өнөөдөр Монголын 18 их, дээд сургуульд сэтгүүлч боловсон хүчин бэлтгэж буй. Дөрвөн жилийн сургалтаар. Давтан сургалт бол бүр үгүй болсон.

Монголын их, дээд сургуулиуд Европын сургалтын стандартыг авч, бараг бүгдээрээ кредит цагийн системд шилжсэн. Академик сургалтаас аль болохоор зайлсхийж, прагматик сургалтыг чухалчилж байгаа. Энэ бол мэдээж хөгжил дэвшил мөн. Тэгэхдээ энд бас нэг доголдол байх шиг санагддаг. Бид өнөөдөр Европын стандартаар нэгэн загварын тоосго үйлдвэрлэж байна. Сайн чанарын тоосго гэдэгт бүгдээрээ бүрэн итгэлтэй байгаа. Тийм ч биз. Энэ нь инженер, техникийн чиглэлийн сургалт, орчин үеийн шинжлэх ухааны тодорхой салбарууд дээр ярих юм байхгүй. Ашигтай.

Гэвч эл үйлдэл, үйл ажиллагаа маань дорнын уламжлал, тодруулбал Монголын өөрийнх нь олон зууны сургалтын өв уламжлалтай хэр зэрэг нийцэж байна вэ гэдгийг хааяа нэг ч гэсэн бодож үзэхэд илүүдэхгүй л болов уу гэж санагддаг. Ялангуяа төрөлхийн авьяас билэг, нөр хичээнгүй хөдөлмөр

зүтгэл, уйгагүй ганцаарчилсан арга ажиллагаа шаардсан зарим мэргэжил, жишээлбэл сэтгүүлчийн мэргэжил эзэмшүүлэх үйл хэрэг дээр. Сэтгүүлчийн мэргэжил бол мэргэжлийн уран зохиолч, дуурийн болоод мэргэжлийн уртын дуучин, мэргэжлийн зураач, хөгжмийн зохиолчийг бэлтгэж төрүүлэхтэй яг адилхан уран бүтээлч, өвөрмөц нарийн чимхлүүр үйл ажиллагаа юм.

**М**онголын уламжлал бол номын багшид хадаг барьж шавь орох, тэгээд дагаж дадлагажих үйл ажиллагаа. Өөрөөр хэлбэл, “багш, шавийн барилдлага” тогтоож уйгагүйгээр олон жилийн турш шамдан хөдөлмөрлөх нүсэр хүнд хэцүү үйл явц. Хараад байхад Цэндийн Дамдинсүрэн, Бямбын Ринчен зэрэг ихэст гэрээр нь шавь болж дагалдсан эрхмүүд л илүү амжилтад хүрч, илүү чамбай бүтээл туурвисан байдаг билээ. Тиймээс бид их, дээд сургуулиар сэтгүүлч боловсон хүчнийг бэлтгэхдээ Европын стандартыг бүтээлчээр ашиглахын зэрэгцээ Монголын уламжлалт шавь сургалтыг хослуулж туршихад илүүдэхгүй санагддаг.

“Улаанбаатар Эрдэм” Их Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимд үүнийг миний бие сүүлийн арваад жилд туршиж үзэж байна. Болмоор санагдаж байгаа. Оюутнууддаа бид үндсэн хоёр шаардлага тавьдаг. Курс, дадлагын ажлын сэдвээ эхнээсээ нухацтай, бодолтойгоор сонгон авч тууштай үргэлжлүүлж төгсөхдөө дипломын ажил болгон өргөжүүлж хамгаалах. Гуравдугаар ангиасаа эхлэн Монгол Улсын аль нэг Ардын уран зохиолч, Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн, Дашдоржийн Нацагдоржийн буюу Жамсраны Цэвээний шагналтай, өөрийн хүссэн, дагалдан дуурайх дур

сонирхолтой байгаа нэр бүхий уран бүтээлчид хадаг барин шавь орох (Энэ үйл ажиллагаа 4 жилийн сургалтаар шувтарга болохгүй, насан туршид ч үргэлжилж болно). Үүнд оюутнууд их дуртай.

Энэ мэтээр хойш тавилгүй хийж хэрэгжүүлэх ёстой тулгамдсан асуудал Монголын сэтгүүл зүйн салбарт олон байна. Би энд дан ганц онол ярьсангүй. Практик асуудлуудыг ч хөндөж хүмүүсийн анхааралд өртүүлэхийг хүслээ.

### Ишлэл

- <sup>1</sup> Баасансүрэн Т. 2009. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. Тэргүүн дэвтэр. УБ.
- <sup>2</sup> Зулькафиль М. 2016. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд-III. Орчин үеийн Медиа: шинэчлэл, чиг хандлага. УБ., х.193.
- <sup>3</sup> Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал // <http://www.mfa.gov.mn>
- <sup>4</sup> “Зууны мэдээ”. 2017.2.22. № 40 /5487/

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2009-2016. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн тогтсон нь. Боть I-VI. УБ.
2. Болд-Эрдэнэ Б. 2014. Нийгэм. Интернет. Сэтгүүл зүй. УБ.

3. Зулькафиль М. 2015. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд-I. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.
4. Зулькафиль М. 2016. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд-III. Орчин үеийн Медиа: шинэчлэл, чиг хандлага. УБ.
5. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.
6. Прохоров Е.П. 2008. Демократия и журналистика. М.
7. Тертычный А.А. 2004. Расследовательская журналистика. М.
8. Фред С. Сиберт нар. Хэвлэл мэдээллийн дөрвөн онол (Орч. М.Зулькафиль, Г.Өнөрбаяр). УБ.

### Резюме

В статье посвящена актуальным вопросам формирования независимой прессы и проблемы развития современной монгольской журналистики. Автор опираясь на практические примеры СМИ и правовые акты, которые регулируют деятельность СМИ Монголии отмечает о необходимости совершенствования нынешних правовых актов о СМИ, интенсивного развития критики о публикациях и передачах СМИ, улучшения работы по подготовке журналистских кадров в вузах и безопасности информации, развития новых направлений журналистики, в том числе расследовательской журналистики.